

Засгийн газрын 2024 оны ... дугаар
сарын ...-ны өдрийн дугаар
тогтоолын хавсралт

ИМПОРТЛОХ, ЭКСПОРТЛОХ СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь хүн амын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор импортлох, экспортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдалд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Импортлох, экспортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдалд хяналт тавихад Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай, Зөвшөөрлийн тухай, Гаалийн тухай, Төрийн хяналт, шалгалтын тухай, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үйлчилгээний итгэмжлэлийн тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан холбогдох журам, стандартыг дагаж мөрдөнө.

1.3.Согтууруулах ундаа импортлох, экспортлох хуулийн этгээд тусгай зөвшөөрөл эзэмшигч байна.

Хоёр.Импортлох, экспортлох согтууруулах ундааны
чанар, аюулгүй байдалд тавих нийтлэг шаардлага

2.1.Импортлох, экспортлох согтууруулах ундааны аюулгүй байдал нь иргэдийн амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөл учруулах эрсдэлгүй байна.

2.2.Импортлох, экспортлох согтууруулах ундаа нь Монгол Улсын болон Олон улс, бүс нутгийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн чанар, аюулгүй байдал, стандарт, техникийн зохицуулалтад заасан аюулгүйн үзүүлэлтийн шаардлагыг хангасан байна.

2.3.Импортлох, экспортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын шинж чанарыг биологийн, химийн, цацрагийн гэсэн гурван ангиллаар тодорхойлно.

2.4.Импортлох, экспортлох согтууруулах ундааны биологийн аюулгүй байдлыг микробиологийн болон эрүүл ахуйн үзүүлэлтээр, химийн болон цацрагийн аюулгүй байдлын шинж чанарыг физик-химийн үзүүлэлтээр тус тус тодорхойлно.

2.5.Лабораторийн шинжилгээний хяналтад химийн, хор судлалын, хүнд металлын, нян судлалын, цацрагийн бохирдлын шинжилгээ хийх асуудал хамаарна.

2.6.Импортлох, экспортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдал нь тухайн бүтээгдэхүүний нэр төрөл тус бүрийн дээжид хийсэн шинжилгээний үр дүн холбогдох техникийн зохицуулалт ба стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхээр тодорхойлогдоно.

2.7.Чанарыг үнэлэхдээ тухайн нэр төрлийн согтууруулах ундааны гадаад шинж чанарт мэдрэхүйн үнэлгээ хийж, холбогдох үзүүлэлтийг тодорхойлно.

2.8.Аюулгүй байдлыг үнэлэхдээ тухайн нэр төрлийн согтууруулах ундааны физик, химийн шинж чанарт хэмжилтийн аргаар шинжилгээ хийж, тодорхойлно.

2.9.Согтууруулах ундааны мэдрэхүйн үнэлгээний шинж чанарт тухайн нэр төрлийн бүтээгдэхүүний өнгө, амт, үнэр, булингар, тунгалаг болон тунадасжилт

гэсэн үзүүлэлтүүд хамаарах ба тэдгээр нь холбогдох стандарт, техникийн зохицуулалтад заасан үзүүлэлтийн шаардлагыг хангасан байна.

2.10.Согтууруулах ундааны физик, химийн шинж чанарт тухайн нэр төрлийн бүтээгдэхүүний спирт, сахар, дэгдэмхий хүчил, хүхрийн хүчил, хүнд металлын давс, титрлэгдэх хүчиллэгийн агууламжийн үзүүлэлтүүд хамаарах ба дүүргэлтийн үзүүлэлтийг мөн харгалзана.

2.11.Согтууруулах ундаан дах цацраг идэвхт бодисын агууламжийг магадлан итгэмжлэх шинжилгээний үр дүнд суурилан тодорхойлж, баталгаажуулсан байна.

2.12.Импортлох, экспортлох согтууруулах ундааны нэр төрөл тус бүрийн шинжилгээний үзүүлэлт нь Монгол Улс, олон улсын стандарт, техникийн зохицуулалтын үзүүлэлтэд нийцсэн байна.

2.13.Импортлох, экспортлох согтууруулах ундааны нэр төрөл тус бүр нь техникийн зохицуулалтад заасан шаардлагыг хангасан, бүтээгдэхүүний үйлдвэрлэсэн болон дуусах хугацаа нь баримт бичиг, шошгод мэдээлсэн байна.

2.14.Импортлох, экспортлох согтууруулах ундаанд хүний эрүүл мэндэд аюул учруулах халдварт, паразит өвчний үүсгэгч бодис, тэдгээрийн хорт бодис байхыг хориглоно.

2.15.Импортлох, экспортлох согтууруулах ундаа нь үйлдвэрлэсэн улс орны чанар, стандартын шаардлага хангаж байгааг эрх бүхий лабораторид шалгаж, тодорхойлсон гэрчилгээ, баримт бичигтэй байна.

Гурав.Импортлох, экспортлох согтууруулах ундаанд хяналт тавихад баримтлах нийтлэг зарчим

3.1.Импортлох, экспортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдалд хяналт тавихдаа Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан хяналт шалгалтын үйл ажиллагааны горим, үндсэн шаардлага болон Засгийн газраас баталсан Хяналт шалгалт хийх нийтлэг журмыг тус тус мөрдлөг болгоно.

3.2.Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий этгээд хяналт шалгалтын үйл ажиллагааны чиг үүргийг хэрэгжүүлэхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4.1-д заасан зарчмыг баримтлахаас гадна хяналт шалгалтад мэдээллийн технологийн дэвшлийг ашиглаж, хяналт шалгалт, түүний үр дүнг цахим хэлбэрээр бүртгэнэ.

3.3.Импортлох, экспортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдалд тавих төрийн хяналт шалгалт нь тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн энэ чиглэлийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн нь холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэхэд чиглэгдэнэ.

3.4.Согтууруулах ундааны мэдрэхүйн үнэлгээ болон физик-химийн шинж чанарын үзүүлэлт нь тухайн бүтээгдэхүүний нэр төрөл тус бүрийн жорд заасан утга, агууламжийн нийцэлд тохирч байгаа эсэхэд хяналт тавина.

3.5.Улсын байцаагч нь энэ журмын 1.2-д заасан хууль тогтоомжийн холбогдох заалт болон 3.4-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавих ба хүний амь нас, эрүүл мэнд, нийгмийн болон хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах зарчмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

3.6.Импортлох, экспортлох согтууруулах ундаа нь стандарт, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн байдлыг тохирлын баталгаа, шинэ төрлийн согтууруулах ундаанд улсын бүртгэл хийгдсэн байдлаар хянана.

3.7.Импортлох, экспортлох согтууруулах ундааны хяналт нь баримт бичгийн хяналт, биет үзлэг шалгалт хийсний үндсэн дээр баталгаажуулалтыг хийнэ. Энэ үед эрх бүхий этгээдээс баталсан хяналтын хуудсыг ашиглана.

3.8.Хүнсний аюулгүй байдал алдагдах, нийтийг хамарсан хордлогын тохиолдол, нөхцөл байдал үүсэх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, үүссэн үед хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг холбогдох хууль, журмаар зохицуулна.

3.9.Зөвшөөрөл эзэмшигч нь импортлогч, экспортлогч улсын үйлдвэр, худалдааны байгууллагатай шууд, эсхүл түүний албан ёсны гэрээт борлуулагчтай худалдааны гэрээ байгуулсан байна.

3.10.Импортлох, экспортлох согтууруулах ундааг хадгалах, тээвэрлэх үйл явц нь холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн байна.

3.11.Согтууруулах ундаа нь хадгалах хугацааны туршид түүний хэрэглээний шинж чанарыг хадгалж, аюулгүй байдлыг хангах нэр төрөлдөө тохирсон зориулалтын сав, баглаа боодол, бөглөөтэй байна.

3.12.Импортлох, экспортлох согтууруулах ундааг стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан зориулалтын агуулахад хадгалж, хадгалалтын горим хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

3.13.Импортлох, экспортлох согтууруулах ундааг хагарах, гэмтэх анхааруулах тэмдэг бүхий сав баглаа боодолтойгоор зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх асуудлыг үйл ажиллагаа эрхлэгч хариуцна.

3.14.Стандарт, техникийн зохицуулалтад зааснаас өөр үнэр, амттай, булингартай, тунадастай согтууруулах ундаа импортлох, экспортлох тохиолдолд холбогдох хууль журмын дагуу арга хэмжээ авч, буцаалт хийнэ.

Дөрөв. Импортлох согтууруулах ундааны чанар,
аюулгүй байдалд тавих хяналт

4.1.Импортлох согтууруулах ундааг Засгийн газраас тогтоосон хилийн боомтоор нэвтрүүлнэ.

4.2.Монгол Улсад бүртгэлтэй тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд согтууруулах ундааг импортлох бөгөөд хувь хүн нийтийн хэрэгцээнд худалдаалах зорилгоор импортлохгүй.

4.3.Импортлох согтууруулах ундаа нь Монгол Улсад импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийн техникийн зохицуулалтад заасан шаардлагыг хангасан байна.

4.4.Импортлох согтууруулах ундаа нь зохистой дадал, аюулын дүн шинжилгээ ба эгзэгтэй цэгийн хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, баталгаажуулсан үйлдвэрээс нийлүүлэгдсэн байна.

4.5.Монгол Улсын хилээр нэвтрүүлэх импортын согтууруулах ундаа нь нэр төрөл тус бүрээр чанар, аюулгүй байдлын шинжилгээг хийлгэсэн бичиг баримттай байна.

4.6.Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд нь импортлох согтууруулах ундааны загвар дээжийг гаалийн байгууллагын лабораторийн урьдчилсан шинжилгээнд хамруулж, эрүүл ахуйн шаардлага хангасан байдлыг тодорхойлуулна.

4.7.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь чанар, аюулгүй байдлыг баталгаажуулсан согтууруулах ундааг импортлох нийтлэг шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

4.7.1.экспортлогч улсын эрх бүхий байгууллагаас олгосон гарал үүслийн гэрчилгээтэй байх;

4.7.2.онцгой албан татварын тэмдэг бүхий согтууруулах ундаа импортлох;

4.7.3.цахим төлбөрийн баримтын систем, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдсон байх;

4.7.4.импортын согтууруулах ундааг хадгалах агуулах, байгууламжийн аюулгүй байдлыг хангаж, дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулсан байх;

4.8.Согтууруулах ундааг тусгай зөвшөөрөлгүй, эсхүл бусад этгээдийн тусгай зөвшөөрөл ашиглан импортлохыг хориглох ба согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрлийг худалдах, бэлэглэх, барьцаалах, түрээслэх зэрэг аливаа хэлбэрээр бусдад шилжүүлээгүй, ашиглуулаагүй байна.

4.9.Импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлыг тодорхойлоход гаалийн байгууллагын лабораторийн журамд тусгасан хэм хэмжээг баримтална.

4.10.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь импортолж буй согтууруулах ундааны нэр төрөл тус бүрийн чанар, аюулгүй байдлыг хуулийн өмнө бүрэн хариуцаж, буруутай үйл ажиллагааныхаа улмаас учирсан хохирлыг барагдуулна.

4.11.Монгол Улсын хилээр нэвтрүүлэх үед импортолсон согтууруулах ундааны хадгалах хугацааны гуравны хоёр нь хүчинтэй хугацаа байна.

4.12.Импортын согтууруулах ундааны шошгод агуулагдах мэдээлэл нь монгол, эсхүл англи, орос хэлний аль нэгээр бичигдсэн, Хүнсний тухай хуулийн шошгод тавигдах шаардлагыг бүрэн хангасан байна.

4.13.Импортын согтууруулах ундааг шошго дээр заасан нөхцөлийн дагуу хадгална.

4.14.Импортын согтууруулах ундааг худалдахдаа худалдан авагчид тухайн бүтээгдэхүүний нэр төрөл, хатуулаг, үүсч болзошгүй эрсдэл, аюулгүй ажиллагааны лавлах мэдээллийг монгол хэлээр орчуулж, заавал дагалдуулна.

4.15.Импортын согтууруулах ундаанд аюулгүй байдлын ноцтой нөхцөл үүссэн үед “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам”-аар зохицуулна.

Тав. Экспортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдалд тавих хяналт

5.1.Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн эрхтэй хуулийн этгээд согтууруулах ундааг экспортолно.

5.2.Согтууруулах ундаа экспортлох этгээд нь стандартын шаардлага хангасан, техникийн зохицуулалт, чанар, аюулгүй байдлыг баталгаажуулсан, тохирлын гэрчилгээ бүхий согтууруулах ундааг экспортолно.

5.3.Согтууруулах ундаа экспортлогч нь тухайн нэр төрлийн бүтээгдэхүүний болон түүнийг үйлдвэрлэхэд ашигласан түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлыг бүрэн хариуцна. Бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын лавлах мэдээллийг заавал дагалдуулна.

5.4.Согтууруулах ундаа экспортлох этгээд нь дээрх нийтлэг шаардлагаас гадна дараах шаардлагыг хангана:

5.4.1.Экспортлох согтууруулах ундааг үйлдвэрлэсэн, үйлдвэрийн байгууламж, агуулах, хог хаягдлыг хадгалах, зайлуулах нөхцөл нь байгаль орчинд хор хөнөөлгүй болохыг нөлөөллийн үнэлгээгээр баталгаажуулсан байна.

5.4.2.Согтууруулах ундааны үйлдвэрлэлд ашиглах үндсэн техник, тоног төхөөрөмж, түүхий эд, бусад бараа материал нь холбогдох техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн, үйлдвэрлэлийн үе шат бүрд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

5.4.3.Согтууруулах ундаа экспортлох этгээд нь онцгой албан татварын тэмдэг наах, мэдээллийг бүртгэх тоног төхөөрөмжтэй байх ба татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдсон байна.

5.4.4.Экспортлох согтууруулах ундаа нь чанар, аюулгүй байдлын стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг импортлох улсын согтууруулах ундаанд тавьсан чанар, стандартын шаардлага хангаж байгааг баталгаажуулж, гэрчилгээ, баримт бичгийг бүрдүүлнэ:

5.5.Экспортлох зориулалттай 18 ба түүнээс дээш хувийн хатуулагтай этилийн спирт агуулсан согтууруулах ундааг 0.33 литрээс бага, 1 литрээс их хэмжээгээр савлахгүй.

5.6.Экспортлох согтууруулах ундаа үйлдвэрлэхэд ашигласан түүхий эд, ус нь импортлогч орны хууль тогтоомж, техникийн зохицуулалтаар тогтоосон шаардлагыг хангасан байна.

5.7.Согтууруулах ундаа үйлдвэрлэхэд ашигласан амт оруулагч, хүнсний нэмэлт, ферментийн бэлдмэл, технологийн туслах хэрэгслүүд нь "Хүнсний нэмэлт, амтлагч, технологийн туслах хэрэгслийн аюулгүй байдлын шаардлага"-ыг хангасан байна.

5.8.Экспортлох согтууруулах ундааны аюулгүй байдал нь тусгай зөвшөөрөл бүхий үйлдвэрлэгчийн дараах үйл ажиллагааны баталгаажуулалтаар тодорхойлогдоно.

5.8.1.Экспортлогч нь согтууруулах ундаа үйлдвэрлэх дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг баталж, мөрддөг байх;

5.8.2.дотоодын хяналтын лабораторитой, чанарын алба, нэгж, ажилтан нь бүтээгдэхүүний цуврал бүрийг дотоодын хяналтын лабораторийн сорилтын үр дүнг үндэслэн чанарыг баталгаажуулдаг байх;

5.8.3.үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд, материал, хэрэглэж буй ус, бэлэн бүтээгдэхүүнд стандартад заасан аюулгүй байдлын үзүүлэлт, физик, хими, механикийн болон мэдрэхүйн үзүүлэлтийг үздэг байх;

5.8.4.түүхий эд, бүтээгдэхүүнийг улиралд нэгээс доошгүй удаа итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулдаг байх;

5.8.5.шинээр үйлдвэрлэл эхэлсэн эсхүл удаан хугацаагаар завсарлаад үйлдвэрлэл эрхэлсэн бол түүхий эд, бүтээгдэхүүнийг хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторид иж бүрэн шинжилгээг хийлгэсэн байх;

5.8.6.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох "урагш нэг шат" бүртгэл, бүтээгдэхүүн борлуулалтын "хойш нэг шат" бүртгэлийг хөтөлдөг байх;

5.8.7.Хүнсний бүтээгдэхүүний зураасан код, цувралын дугаар хэрэглэдэг;

5.8.8.Бүтээгдэхүүний шошгын мэдээлэл нь холбогдох хууль тогтоомжид заасан шаардлага хангасан байх;

5.9.Согтууруулах ундаа экспортлогч нь хуурамч бүтээгдэхүүнээс сэргийлсэн бүтээгдэхүүний нууцлал бүхий бүртгэлтэй, буцаан татах механизмыг бүрдүүлнэ.

Зургаа.Импортлох, экспортлох согтууруулах ундааг улсын хилээр нэвтрүүлэхэд тавих хяналт

6.1.Импортлох, экспортлох согтууруулах ундааг улсын хилээр нэвтрүүлэх гаалийн бүрдүүлэлт болон бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд хяналт тавих үйл ажиллагааг Гаалийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлнэ.

6.2.Импортын согтууруулах ундааг улсын хилээр нэвтрүүлэх үед эрсдэлд суурилсан гаалийн хяналтыг хийнэ.

6.3.Импортын согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлыг үнэлэхдээ санамсаргүй түүврийн аргаар дээж авч, шинжилгээнд хамруулж, холбогдох шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянана.

6.4.Экспортлох согтууруулах ундааны гарал үүсэл, тохирлын гэрчилгээ, чанар, аюулгүй байдлыг баталсан лабораторийн сорилтын дүн, худалдааны гэрээг үндэслэн улсын хилээр нэвтрүүлнэ.

6.5.Импортлох, экспортлох согтууруулах ундааг улсын хилээр тээвэрлэн нэвтрүүлэхэд Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журмыг мөрдөнө.

6.6.Согтууруулах ундаа импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэхээс өмнө тухайн нэвтрүүлэх боомт дахь холбогдох хяналтын албанд урьдчилан мэдэгдэнэ.

6.7.Согтууруулах ундаа импортлох, экспортлох үйл ажиллагааны хяналт шалгалтыг эрх бүхий албан тушаалтны баталсан хяналтын хуудсыг ашиглана.

6.8.Улсын байцаагч хяналтын хуудасны асуултын хүрээнд согтууруулах ундааны шалгалт хийхдээ асуулт тус бүрд үнэлгээ тавьж, үнэлгээний нэгтгэлээр тухайн шалгуулагч этгээдийн үйлдвэрлэл, үйлчилгээ хууль тогтоомжид заасан шаардлагыг хэрхэн хангаж байгаа, хангаагүйгээс ямар төвшний эрсдэл гарахыг тодорхойлно.

6.9.Хяналтын хуудсаар хяналт шалгалт хийсэн тухай бүр төв, орон нутгийн хүнсний хяналтын байгууллагуудад бүртгэл мэдээллийн сан, зөрчлийн түүх бүрдүүлнэ. Энэ мэдээллийн баазад үндэслэн дараа жилийн төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах эрсдэл бүхий бизнес эрхлэгчдийн нэрсийг гаргахад ашиглана.

6.10.Импортын согтууруулах ундаа нь хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлснийг баталгаажуулсан үйлдвэрийнх болохыг бичиг баримтаар баталгаажуулна.

6.11.Импортлох, экспортлох буй согтууруулах ундаанд холбогдох бичиг баримтын зөрчил байгаа эсэхэд биет үзлэг, шалгалт хийнэ.

6.12.Баримт бичиг болон биет үзлэг, шалгалт, бусад шалгалтаар зөрчил илрээгүй, лабораторийн шинжилгээнд хамруулах шаардлагагүй тохиолдолд улсын байцаагч нь согтууруулах ундааг холбогдох хяналт шалгалтаас чөлөөлж, гаалийн бүрдүүлэлт хийх, мэдэгдлийг зөвшөөрөл эзэмшигчид өгч улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгоно.

6.13.Баримт бичгийн болон биет үзлэг, шалгалтаар зөрчил илэрсэн тохиолдолд согтууруулах ундаа бүхий ачааг 72 цаг хүртэл хугацаагаар тур саатуулах, гаалийн болон холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

6.14.Түр саатуулах хугацаанд зөрчил арилаагүй тохиолдолд согтууруулах ундаа бүхий ачааг хариуцагч этгээдийн зардлаар экспортлогч улсад буцаах, эсвэл холбогдох хуульд заасны дагуу улсын орлого болгон хурааж авна.

6.15.Импортын согтууруулах ундаа нь чанар, аюулгүй байдлын шаардлага хангаагүй бол тухайн этгээдийн зардлаар буцаана.

6.16.Импортлох, экспортлох согтууруулах ундааны чанар, аюултай байдлын хяналт шалгалтыг холбогдох хяналтын байгууллага/улсын байцаагчаас олгосон дүгнэлтэд үндэслэн хяналт шалгалт хийх ба шаардлагатай тохиолдолд согтууруулах ундаанаас дээж авна.

6.17.Согтууруулах ундааг улсын хилээр нэвтрүүлэхэд экспортлогч талын эрх бүхий байгууллагаас олгосон чанар, аюулгүй байдлын баталгаажуулалтын баримт бичиг, энэ журмын 4.1.4-д заасан үйлдвэрлэгчийн лавлах мэдээллийн хуудас, тээврийн гэрээ, худалдааны гэрээ болон түүнтэй адилтгах баримт бичгийг хариуцагч бүрдүүлсэн байна.

Долоо. Согтууруулах ундаа импортлох, экспортлоход оролцогч талуудын тавих хяналтын үүрэг

7.1.Согтууруулах ундааны импорт, экспортод тавих хяналтыг гаалийн байгууллага болон хилийн эрүүл ахуйн хяналтын алба, хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус хэрэгжүүлнэ.

7.2.Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний харьяа гаалийн байгууллага нь импортолж байгаа согтууруулах ундааны техникийн зохицуулалтад заасан стандарт, чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийн шаардлага хангасан байдалд хяналт тавьж, дүгнэлт гаргана.

7.3.Согтууруулах ундааны мэдээллийн цахим сан, цахим төлбөрийн баримтын системд холбогдсон байна.

7.4.Гаалийн байгууллага нь импортолсон, экспортолсон согтууруулах ундааны талаарх мэдээг нэвтэрсэн хилийн боомт, хуулийн этгээдийн нэрээр болон согтууруулах ундааны нэр төрөл, тоо, хэмжээгээр гаргаж, жил бүрийн 7 дугаар сар, дараа оны 1 дүгээр сард багтаан хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

7.5.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хяналтыг хяналт шалгалтын эрх бүхий байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлнэ.

7.6.Энэ журмын 4.9-д заасан байгууллага нь хяналтын үр дүнг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хагас жил тутамд нэг удаа хүргүүлж байна.

7.7.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хяналтын дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.7.1.дангаар болон хамтран хүнсний сүлжээнд нийлүүлсэн импортолсон согтууруулах ундаанд санамсаргүй түүврийн аргаар эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлж, чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан байдалд хяналт, шалгалт хийж болно.

7.7.2.согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл олгосноос хойш хоёр жил, түүнээс дээш хугацаанд согтууруулах ундаа импортлоогүй этгээдийн тусгай зөвшөөрлийн эрхийг цуцлах

7.7.3.импортолсон согтууруулах ундааны гадаад төрх байдал, сав баглаа боодол, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын үзүүлэлт, зохистой хэрэглээний талаар хэрэглэгчдэд зориулж таниулах арга хэмжээг хэрэгжүүлэх

7.7.4.төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийх

7.7.5.импортлох, экспортлох согтууруулах ундааны зөвшөөрөл бүхий эрх эзэмшигчдэд зөвлөн туслах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, тандалт судалгаа, сургалт, зөвлөмж өгөх

7.7.6.бусад

7.8.Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд импортолсон, экспортолсон болон чөлөөт бүс, татваргүй барааны дэлгүүрт оруулсан бүх төрлийн согтууруулах ундааг үйлдвэрлэл, импорт, борлуулалтын үе шат бүрээр эцсийн хэрэглэгч хүртэл цахим төлбөрийн баримт, гаалийн мэдүүлэгт үндэслэн бүртгэнэ.

7.9.Импортолсон, экспортлох согтууруулах ундаанд эрх бүхий хуулийн этгээд хяналтын дотоод лабораторид болон үндэсний лавлагаа лабораторид дараах хяналтын шинжилгээ хийлгэнэ.

7.9.1.эрүүл ахуйн нян судлалын хяналтын лаборатори

7.9.2.эрүүл ахуй хими, хор судлалын хяналтын лаборатори

7.9.3.цацрагийн хяналтын лаборатори

7.10.Үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн лаборатори нь согтууруулах ундааны бүтээгдэхүүн, түүнийг дээжийг сонгож эсхүл хүсэлтийн дагуу шинжлэн, үр

дүн нь техникийн зохицуулалтын шаардлагад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулна.

7.11.Лабораторийн шинжилгээнд шаардлагатай дээжийг эрх бүхий улсын байцаагч эсвэл ажилтан холбогдох журам, аргачлалын дагуу протокол үйлдэн авч, лабораторид хүргүүлнэ.

7.12.Лаборатори нь маргаан таслах, үр дүнг баталгаажуулах зорилгоор загвар дээжийг авч, хадгалах, хамгаалах, харьцах журмыг мөрдөнө.

7.13.Импортын согтууруулах ундаанд эрсдэлийн үнэлгээ хийхэд согтууруулах ундааны нэр төрлөөс хамааран салбар хоорондын итгэмжлэгдсэн лабораториуд хамтран ажиллаж болно.

7.14.Лаборатори бүр хийсэн шинжилгээний дүн мэдээг согтууруулах ундааны мэдээллийн нэгдсэн санд тухай бүрд хүргүүлэх ба шинжилгээний дүнгийн мэдээллийн үнэн зөв, бодитой байдлыг мэдээлэл оруулсан лаборатори бүрэн хариуцна.

7.15.Итгэмжлэгдсэн лабораториудын сорилтын үр дүнд зөрүү гарсан тохиолдолд маргаан таслах сорилтыг хөндлөнгийн итгэмжлэгдсэн лаборатори эсвэл зохицуулагч байгууллагаас томилогдсон лаборатори гүйцэтгэж болно.

7.16.Монгол Улсын хэмжээнд тухайн сорилтыг гүйцэтгэх итгэмжлэгдсэн лаборатори байхгүй тохиолдолд Олон улс, бүс нутгийн итгэмжлэгдсэн лабораторид дээжийг хүргүүлж, шинжлүүлж болно.

7.17 Согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах үүргийг хүлээнэ.

7.17.1.Согтууруулах ундааны техникийн зохицуулалтын шаардлагыг хангасан, бүтээгдэхүүн импортолно.

7.17.2.Импортын согтууруулах ундаа нь зохистой дадал эсхүл хяналт, удирдлагын тогтолцоог нэвтрүүлснийг баталгаажуулсан үйлдвэрийнх байх

7.17.3.Импортын үе шат бүрд дотоод хяналтыг хэрэгжүүлж, түүхий эд, бүтээгдэхүүнийхээ чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлыг бүрэн хариуцна.

7.17.4.Бүтээгдэхүүний цуврал бүрийг итгэмжилсэн лабораторийн сорилтын үр дүнг үндэслэн чанарын гэрчилгээ үйлдэн баталгаажуулж, худалдаа, үйлчилгээнд гаргана.

7.17.5.Хуурамчаар импортлогдож байгаа согтууруулах ундааг илрүүлэх, сэжигтэй тохиолдолд холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

Найм.Импортлох, экспортлох согтууруулах ундааны хяналтын мэдээллийн сан

8.1.Импортлох, экспортлох согтууруулах ундаанд хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь холбогдох хяналтыг явуулахдаа "Согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох, худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бүртгэл болон холбогдох бусад мэдээллийг агуулсан мэдээллийн цахим санг бүрдүүлэх, ашиглах, баяжуулах журам"-ыг мөрдлөг болгоно.

8.2.Согтууруулах ундааны хяналтад оролцогч төрийн байгууллагууд дараах байдлаар мэдээллээ солилцож мэдээллийн сан бүрдүүлнэ.

8.3.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь согтууруулах ундааны мэдээллийн цахим санг бүрдүүлэх, ашиглах үйл ажиллагааг хариуцах ба энэ сан нь татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, гаалийн үйл ажиллагааны мэдээллийн сантай холбогдсон байна.

8.4.Согтууруулах ундааны импорт, худалдаа, үйлчилгээнд олон нийтийн хяналт хийсэн төрийн бус байгууллага мэдээ мэдээллээ холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр мэдээлнэ.

8.5.Мэдээллийн санд экспортолсон үйлдвэрлэгчийн нэр, худалдсан этгээдийн нэр, импортолсон тохиолдолд импортлогчийн нэр, үйлдвэрлэсэн он, сар, өдөр, тоо, хэмжээ, гаалийн бүрдүүлэлт хийсэн он, сар, өдөр, гаалийн бүрдүүлэлтэд тусгасан гаалийн үнэлгээ, төлсөн онцгой албан татварын дүн гэсэн мэдээллийг бүртгэнэ.

8.6.Хяналт шалгалтын байгууллага, улсын байцаагч нь хяналт шалгалт хийх явцдаа олж авсан хуулиар хамгаалагдсан нууцыг хадгална.

8.7.Тусгай зөвшөөрөл бүхий этгээд нь импортолсон, экспортолсон согтууруулах ундааны нэр төрөл тус бүрээр нийлүүлэлт, зарцуулалтын хөдөлгөөний тухайн жилийн тайланг гаргаж, дараа жилийн 01 дүгээр сарын 25-ны дотор хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар хүргүүлнэ.

Ёс. Хариуцлага

9.1.Хяналт тавьсан байгууллага, эрх бүхий албан тушаалтан нь өөрийн хийсэн хяналт шалгалт, гаргасан шийдвэр, түүний үр дүнг хариуцна.энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

9.2.Энэхүү журмыг зөрчсөн төрийн албан хаагчийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль эсхүл Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

9.3.Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

9.4.Импортлох, экспортлох согтууруулах ундааны мэдээллийн сангийн үйл ажиллагааг санаатай болон санамсаргүйгээр алдагдуулах, хуулийн этгээдийн нууцтай холбоотой мэдээллийг задруулах, мэдээллийг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр арилжааны зорилгоор ашиглах, бусдад дамжуулах, худалдаалахыг хориглоно.

9.5.Үйл ажиллагааг хууль тогтоомжид заасан шаардлагад нийцүүлэх талаар хяналт тавих эрх бүхий байгууллагын хууль ёсны шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд согтууруулах ундаа импортлох тусгай зөвшөөрлийг зөрчлийг арилгуулах зорилгоор гурав хүртэлх сарын хугацаагаар түдгэлзүүлж, зөрчлийг арилгасан бол сэргээнэ.

9.6.Согтууруулах ундаа импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэгч нь энэ талаар гарсан олон улсын гэрээний шаардлагыг биелүүлэх үүрэгтэй ба тээвэрлэлт, ачилт, буулгалтын үед гарч болох осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, осол гэмтэл гарсан тохиолдолд хор, аюулыг бууруулах арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

9.7.Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх болон хуурамч согтууруулах ундаа импортолсон этгээдэд Эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсхүл Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.